ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/36 Өвт

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (Ковид-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүний зардалд 1,650,00 (нэг сая зургаан зуун тавин мянга тавин) төгрөг, сумын Онцгой комиссын өмнөх оны шатахууны зардалд 4,621,770 (дөрвөн сая зургаан зуун хорин нэгэн мянга долоон зуун далан) төгрөг, 2021 оны цэрэг татлага, Онцгой комиссын сургалт, шинэ сум төсвийн ажлын хэсгийн хоолны зардалд 1,425,000 (нэг сая дөрвөн зуун хорин таван мянган) төгрөг, Үүртийн постны жижүүрийн хүнсний зардалд 69,850 (жаран есөн мянга найман зуун тавин) төгрөг, нийт 7.766.620 (долоон сая долоон зуун жаран зургаан мянга зургаан зуун хорин) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 7.766.620 (долоон сая долоон зуун жаран зургаан мянга зургаан зуун хорин) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (С.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

6221020073

D:My Doc A-4 zahiramj /Zasag Darga/